

# Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна



## Сүмийн удирдагч Есүс дээр ирсэн нь

Зохиогч: Edward Hughes  
Зураглаач: Byron Unger; Lazarus

Орчуулсан: Damdin Horolsuren  
Найруулсан: M. Maillot; Sarah S.

Түүх 41/60

[www.M1914.org](http://www.M1914.org)

*Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada*

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл

Mongolian

Нэгэн өдөр Есүс сүмд орж ирээд Бурханы өргөөг үл хүндэтгэсэн хүмүүсийг олж харав. Тэд сүм дотор мал амьтан зарж мөнгө солилцож байлаа.




1

Тэр дээсээр шилбүүр хийж, хонь үхэр бүгдийг нь сүмээс туун гаргаад, мөнгө солигчдын зооснуудыг тараан хаяж ширээг нь хөмрүүлэв. Тэгээд "Энэ юмнуудаа зайлуул" гэж тушаав.




2

"Миний Эцгийн гэрийг наймааны газар болгохоо зогсоо" гэлээ. Есүс Эцгийнхээ гэрийг хайрласандаа тэгжээ.




3

Харин сүмийн ахлагч нар Есүсийг сүмийг цэвэрлэх эрхтэй гэдгээ харуулж тэмдэг үзүүлэхийг шаарджээ.



4

Есүс "Энэ сүмийг устга би үүнийг гурав хоногийн дотор дахин босгох болно" гэв. Байж боломгүй юм! Энэ сүмийг барихад дөчин зургаан жил зарцуулсан билээ.



5

Гэвч Есүс өөрийн биеийн талаар ярьжээ. Ариун сүмийн нэгэн адил, Түүний бие Бурханы орших газар юм. Есүс загалмай дээр нас бараад Бурхан түүнийг гурван өдрийн дотор амилуулна гэдгийн тухай ярьж байсан юм.



6

Нэгэн орой сүмийн ахлагч нарын нэг Есүс дээр иржээ. Тэр Есүсийн үйлдсэн гайхамшгуудыг хараад тэр бол Бурханаас илгээгдсэн нэгэн гэдэгт итгэсэн байв. Никодем Есүс дээр ирж Бурханы тараар илүү ихийг мэдэхийг хүсжээ.



7

Есүс Никодемд хүн дахин төрж байж тэнгэрийн хаанчлалд орно гэв. Никодем үүнийг сайн ойлгосонгүй. Насанд хүрсэн хүн яаж дахин төрөх вэ? Тэрээр их сүсэг бишрэлтэй хүн байв. Сүсэг бишрэлтэй их байлаа ч тэнгэрийн хаанчлалд ороход хангалтгүй гэж үү?



8



Сүнснээс төрсөн нь сүнс юм гэж Есүс тайлбарлав. Бурханы сүнс бол салхи адил юм. Хүмүүс салхийг харж бас хаашаа явсныг нь мэддэггүй. Тэд зөвхөн салхи юу хийснийг нь хардаг.


9



Есүс Никодемд олон жилийн өмнө Израйлийн хөвгүүд Мосед гомдоллож "Бидэнд идэх юм алга, уух ус алга бид Бурханы өгсөн талхыг үзэн ядаж байна" гэж хашхирч байсныг сануулав.

10

Тэр үед хүмүүсийн нүгэл нь Бурханыг уурлуулсан юм. Тэр тэдэн уруу галт могой илгээв. Могойд хатгуулснаас болж олон хүн үхсэн юм.



11

Хүмүүс "Бид нүгэл үйлджээ". Биднээс могойнуудыг холдуулаач гэж залбирч өгөөч хэмээн Мосегоос гуйжээ. Тиймээс Мосе тэдний төлөө залбирав. Гэвч Бурхан могойнуудыг холдуулсангүй.



12

Бухан Мосед -Галт могой хийж, түүнийг шургааны оройд байрлуулагтун. Тэгвэл хатгуулсан хүн бүр түүнийг хараад амьдрах болно гэж амлав. Мосе хүрэл могойг хийж, түүнийг шургааны оройд байрлуулав тэгээд хүрэл могойг харсан хүн болгон эдгэрч байв.



13

Есүс Никодемд Хүний хүү ч бас хүрэл могой адил өргөгдөх ёстой гэв.



Энэ нь Есүс өөрөө нүгэлтэнүүдийн төлөө нас барах загалмайн тухай хэлсэн юм.

14



Есүс "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан бөгөөд цорын ганц хүүгээ илгээсэн ба хүүд итгэгч хэн ч мөхөхгүй харин мөнх амьтай болох юм" гэлээ.

15



Энэ бол Есүст итгэсэн хэн боловч Бурханы гэр бүлийн гишүүн болно гэсэн үг юм.

16



Никодем тэр шөнө Есүсийн дагалдагч болсонгүй. Гэвч нэг жилийн дараа тэр цовдлогдсон Бурханы Хүүг оршуулхад туслан Есүст итгэдэг бөгөөд хайртайгаа батлан харуулсан юм.

17



Үүний дараа Есүс дагалдагч нартайгаа хойд зүг уруу аялав. Энэ нь бусад хүмүүст Бурханы хаанчлалын сайн мэдээг хүргэж Бурханы хүү Есүст итгэх боломж олгохын тулд байлаа.

18

Сүмийн удирдагч Есүс дээр ирсэн нь

Бурханы үг Библээс авсан түүх

Иохан 2-3, Тооллого 21

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130



Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!